



132

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 97

Есөнбулаг сум

**Газар нутгийг орон нутгийн тусгай
хамгаалалтад авах тухай**

Монгол улсын Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.3, 29 дүгээр зүйлийн 29.2, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Байгаль орчны сайдын 2000 оны 07 тоот тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бигэр сумын нутаг дэвсгэрт хамаарах Өөш нэртэй газрыг түүх соёлын дурсгалт зүйлс, байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрх, ховор амьтан, ургамал тэдгээрийн тархац нутгийг хадгалж хамгаалах зорилгоор 30 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2. Аймгийн тусгай хамгаалттай газар нутгийн нэр, талбайн хэмжээ, эргэлтийн цэгүүдийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх тусгай хамгаалалтад авсан газар нутагт явуулах үйл ажиллагааны журам, хамгаалалтын горим боловсруулж мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/- д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

243
133

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар
сарын 27-ний өдрийн 27 дугаар
тогтоолын хавсралт



Говь-Алтай аймгийн Бигэр сумын тусгай хамгаалалтанд
авсан газар нутгийн нэр, эргэлтийн цэгүүд

№	Сумын нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Эргэлтийн цэг	
				у	х
1	Бигэр	Өөш	5290	45°46'45,927"	96°47'36,341"
2				45°44'59,741"	96°47'58,602"
3				45°42'09,731"	96°51'00,704"
4				45°42'05,382"	96°58'34,905"
5				45°47'01,272"	96°58'08,701"